

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газар




ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**“АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨРИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ЧИГЛЭГДСЭН ХӨТӨЛБӨРҮҮДИЙН
ТӨЛӨВЛӨЛТ, ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ” ГҮЙЦЭТГЭЛИЙН
АУДИТЫН ТАЙЛАН**

АУДИТЫН КОД: ХЭА-2021/02/-ГА

Хэрлэн сум 2021 он



Аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар

Утас: 70562112 Цахим хаяг: erdenebaatararch@audit.gov.mn

Аудитын менежер Д.Оюунтуяа

Утас: 70562147 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn

Ахлах аудитор Д.Эрдэнэбилэг

Утас: 70562147 Цахим хаяг: erdenebilegd@audit.gov.mn

Аудитор Ц.Энхтүвшин

Утас: 70562147 Цахим хаяг: enkhtuvshints@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу: Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	5
БҮЛЭГ 1. Дэд хөтөлбөрүүдийн зорилго, зорилт, арга хэмжээнүүдийг төлөвлөсөн боловч үр дүнг тооцолгүй баталсан байна.....	7
<i>А.1. Дэд хөтөлбөрүүдийг батлахдаа зорилго, зорилтоо бүрэн тусгасан боловч үр дүнг тодорхойлолгүй орхигдуулсан байна.....</i>	<i>7</i>
<i>А.2 Дэд хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлсон боловч хэрэгжүүлэх ажлын тоо хэмжээг орхигдуулснаас хөтөлбөрийн үр дүнг тооцох боломжгүй болгожээ.....</i>	<i>8</i>
БҮЛЭГ 2. Дэд хөтөлбөрүүд нь тавьсан зорилтдоо хүрсэн эсэхийг тодорхойлох боломжгүй байна.	9
<i>Б.1 Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны дунд хугацааны болон жилийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулахдаа санхүүгийн нөөц, хариуцах нэгж, хүрэх чанарын түвшинг бүрэн тодорхойлж чадаагүй байна.</i>	<i>9</i>
<i>Б.2 Дэд хөтөлбөрүүдэд шаардлагатай санхүүжилтыг бүрэн тооцоогүй, батлагдсан төсвийн үр ашгийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллаагүй байна..</i>	<i>11</i>
<i>Б.3 Дэд хөтөлбөрүүдийн жил бүрийн хэрэгжилтийг дэвшүүлсэн зорилтын хүрээнд нэгтгэн дүгнээгүй, үр нөлөөг тооцоогүй байна.....</i>	<i>13</i>
БҮЛЭГ 3. Дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтэнд хяналт шалгалт хийгдээгүйгээс үр дүнг тооцох боломжгүй байна.	15
<i>В.1 Дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд тавигдах дотоод хяналтын нэгжийн ажил хийгдээгүй байна.</i>	<i>15</i>
<i>В.2 Аймгийн ИТХ-ын хороод нь дэд хөтөлбөрт хяналт тавих ажлаа зохион байгуулаагүй байна.</i>	<i>16</i>
Холбогдох байгууллагын санал:	17
Саналд өгсөн тайлбар:.....	17
ДҮГНЭЛТ: 18	
ЗӨВЛӨМЖ:	19

	ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ТББ	Төрийн бус байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олог улсын стандарт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ААН	Аж ахуйн нэгж
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэрлэл

Дүрслэлийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Дэд хөтөлбөрийн хүрээнд дэвшүүлсэн зорилт, арга хэмжээний тоо	7
Дүрслэл 2	Дэд хөтөлбөрийн хүрээнд хийгдэх үр дүн, шалгуур үзүүлэлтийн тоо	8
Дүрслэл 3	Дэд хөтөлбөрүүдийн төсөв, гүйцэтгэл	12
Дүрслэл 4	Дэд хөтөлбөрийн талаархи иргэдийн ойлголт	13
Дүрслэл 5	Дэд хөтөлбөрийн талаархи иргэдийн үнэлэлт, Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн талаархи иргэдийн үнэлэлт	14

Хавсралтын товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Судалгаа №1	Дэд хөтөлбөрүүдийн зорилго, зорилт, арга хэмжээ болон шалгуур үзүүлэлт	21
Судалгаа №2	Дэд хөтөлбөрүүдийн батлагдсан төсөв, гүйцэтгэл	22
Судалгаа №3	Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн дэд хөтөлбөрүүдийн зардлын судалгаа	23
Судалгаа №4	Дэд хөтөлбөрүүд нь тавьсан зорилтдоо хүрч, үр дүн гарсан эсэх	24

	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэлийн аудитыг хийлээ.
Аудитын зорилт	“Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, аймгийн Засаг даргын Тамгын газар болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв. Аудитын зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: ➤ Дэд хөтөлбөрүүд нь хууль эрх зүйн хүрээнд төлөвлөгдөж, батлагдсан эсэх; ➤ Дэд хөтөлбөрүүд нь тавьсан зорилтдоо хүрч үр дүн гарсан эсэх; ➤ Дэд хөтөлбөрийн хэрэгжилтэнд тавих хяналт үр дүнтэй хэрэгжсэн эсэх;
Аудитын хамарсан хүрээ	Аудитад аймгийн ИТХ, аймгийн ЗДТГ, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч төрийн болон ТББ-ыг хамруулан 2016-2020 онд хэрэгжсэн хөтөлбөрийн арга хэмжээний хэрэгжилтэд аудит хийв.
Аудитын хязгаарлалт	
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 300, 3000-3100 үндэслэн боловсруулсан Гүйцэтгэлийн аудитын журамд заасан арга зүйг ашиглан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгон аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, холбогдох албан тушаалтнуудаас асуулга лавлагаа, тодруулга авах, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийж, аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг аймаг дахь төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Д.Оюунтуяа хэрэгжүүлж, аудитыг ахлах аудитор Д.Эрдэнэбилэг ахлан, аудитор Ц.Энхтүвшин хийж гүйцэтгэв.

Аудитын төлөвлөлтийн үе шатны ажлыг 2021 оны 01 дүгээр сарын 07-ны өдрөөс 18-ний хооронд хийж гүйцэтгэн, аудитыг гүйцэтгэх ажлыг 01 дүгээр сарын 21-ээс 02 дугаар сарын 21-ны өдрүүдэд, тайлагналын үе шатыг 02 дугаар сарын 23-ны дотор дуусган, аудитын тайлан, судалгааг Тэргүүлэх аудиторовн тушаалаар баталгаажуулан 2021 оны 02 дугаар сарын 23-нд Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газар болон аймгийн ИТХ, аймгийн Засаг даргад хүргүүлнэ.

**Хүндрэл
бэрхшээл**

.....

АУДИТЫН ДҮН: ДЭД ХӨТӨЛБӨРҮҮДИЙН ҮР НӨЛӨӨГ ТООЦОЖ, ТАЙЛАНГ ХЭЛЭЛЦҮҮЛЭЭГҮЙ БАЙНА .

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Аймгийн Засаг даргын 2016-2020 оны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүднээс “Ажилтай, орлоготой өрх”, “Хэнтийн брэнд”, “Эрүүл мэнд-Хөдөлгөөн-Хөгжил”, “Архидалтгүй Хэнтий”, “Бүх нийтийн эрх зүйн боловсрол”, “Мянган нуурын хотгор”, “Манай гудамж-гэрэлтэй гудамж”, “Сумын шинэ төв”, “Хоршоог хөгжүүлэх”, “Төрөлх нутагтаа бид”, “Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх”, “Чингис брэнд” зэрэг 12 дэд хөтөлбөрийг 2017-2020 онд хэрэгжүүлэхээр аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээр батлуулсан байна.


Улмаар 2018 онд “Залуучуудын хөгжлийг дэмжих” дэд хөтөлбөрийг 2018-2022 онд, “Бид нэг голынхон” дэд хөтөлбөрийг 2019-2030 онд хэрэгжүүлэхээр нэмж баталжээ.

Дээрх дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх зорилгоор жил бүрийн орон нутгийн төсөвт санхүүжилтийг тусгаж байсан ба 2016-2020 онд нийтдээ 999,4 сая төгрөгийг баталж үүнээс 989,3 сая төгрөгийг зарцуулсан байна.

БҮЛЭГ 1. Дэд хөтөлбөрүүдийн зорилго, зорилт, арга хэмжээнүүдийг төлөвлөсөн боловч үр дүнг тооцоолоогүй баталсан байна.

А.1. Дэд хөтөлбөрүүдийг батлахдаа зорилго, зорилтоо бүрэн тусгасан боловч үр дүнг тодорхойлолгүй орхигдуулсан байна.

Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүднээс баталсан 12 дэд хөтөлбөр нь бүгд зорилгоо тодорхойлсон, нийтдээ 38 зорилтыг хэрэгжүүлэхээр батлуулсан байна.



Дүрслэл 1

Дээрх 12 дэд хөтөлбөрийн хүрээнд нийтдээ 147 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн, түүнийг хэрэгжүүлэгч байгууллагуудыг тогтоон, санхүүжилт, үр дүнг тодорхойлон 2016-2020 онд хэрэгжүүлэхээр тусгасан байна. Гэхдээ тухайн дэд хөтөлбөрүүдийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын тоо хэмжээг, нарийвчлан гаргаагүй, жил бүр тодотгоогүйгээс хэрэгжилтийг үнэлэх боломжгүй байдалд хүрч байна.


Харин тус дэд хөтөлбөрүүдээс "Эрүүл мэнд-Хөгжил хөдөлгөөн" дэд хөтөлбөр л шалгуур үзүүлэлт болон суурь түвшинг тодорхойлон, хүрэх түвшний зорилтыг жил бүрээр, үр дүнг хэмжих боломжтойгоор тодорхойлжээ. Бусад 11 дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх суурь түвшин болон хүрэх түвшинг тодорхойлж, батлуулаагүй нь үр дүнг тооцох боломжгүй болгосон байна.

"Манай гудамж хотгор", "Манай гудамж, гэрэлтэй гудамж", "Сумын шинэ төв" дэд хөтөлбөрүүд хөрөнгө оруулалтын чиглэлтэй бол бусад хөтөлбөрүүдэд тусгагдсан арга хэмжээнүүдэд зураг, төсөл шаардагдахгүй арга хэмжээнүүд байна.

Улмаар аймгийн 2018 онд ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар "Залуучуудын хөгжлийг дэмжих" дэд хөтөлбөрийг баталж, үйл ажиллагааг 2018-2022 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

А.2 Дэд хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлсон боловч хэрэгжүүлэх ажлын тоо хэмжээг орхигдуулснаас хөтөлбөрийн үр дүнг тооцох боломжгүй болгожээ.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлагдсан дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг үнэлэхдээ үр дүнг 42 зорилтоор, шалгуур үзүүлэлтийг 60 арга хэмжээгээр үнэлэхээр тусгасан байна.



Дүрслэл 2

"Хэнтий брэнд", "Эрүүл мэнд-Хөгжил хөдөлгөөн", "Соёлын бүтээлч үйлдвэрлэл" дэд хөтөлбөрүүдийн үр дүнг тодорхойлж гаргаагүй, "Ажилтай, орлоготой өрх", "Архидалтгүй Хэнтий", "Бүх нийтийн эрх зүйн боловсрол", "Чингис брэнд" дэд хөтөлбөрүүдийн үр дүнг тооцох шалгуур үзүүлэлт тодорхойгүй байна.

"Мянган нуурын хотгор", "Манай гудамж, гэрэлтэй гудамж", "Сумын шинэ төв" дэд хөтөлбөрүүдийн хүрээнд хийгдэх жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулагдаж батлагдаагүй, жил бүрийн хөрөнгө оруулалтын хүрээнд хийгдсэн төсөл, арга хэмжээнүүдээс өөр мэдээлэлгүй байсан нь эдгээр дэд хөтөлбөрийн зорилтуудыг хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг хэдэн онд, ямар зардлаар, ямар байгууллага, нэгж хэрхэн хэрэгжүүлэх талаар тодорхой ойлголт авч чадсангүй.

Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүднээс боловсруулсан дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх дунд хугацааны төлөвлөгөөгүй, санхүүжилтийн эх үүсвэр, хэмжээ нь тодорхойгүй байгаагаас үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөнүүдэд тухайн ажил, үйлчилгээний санхүүжих эх үүсвэрийг тодорхойлж чадаагүй байдал түгээмэл харагдаж байна. Зарим жилийн төлөвлөгөөнд санхүүжилтийг тусгасан боловч тэр нь орон нутгийн төсвөөс гаргах хөрөнгийн хэмжээгээр хязгаарлагджээ.

Аймгийн ИТХ-ын 2017 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн тогтоолоор аймгийн ОНХС-аас 2017 онд дэд хөтөлбөрүүдийн зардалд нийт 177,4 сая төгрөгийг, аймгийн ИТХ-ын 2018 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн тогтоолоор аймгийн ОНХС-аас 2018 онд дэд хөтөлбөрүүдийн зардалд нийт 285,0 сая төгрөгийг санхүүжүүлэхээр тус тус батлагджээ.

Гэвч 2018 оны дэд хөтөлбөрүүдийн санхүүжилтээс "Ажилтай, орлоготой өрх", "Хэнтий брэнд", "Хоршоог хөгжүүлэх", "Төрөлх нутагтаа бид", "Чингис брэнд", 2019 онд "Ажилтай орлоготой өрх" дэд хөтөлбөрүүдэд зардал батлаагүй байна.

Харин аймгийн ИТХ-ын 2018 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн тогтоолын 6-р хавсралтаар 2019 онд дэд хөтөлбөрүүдийн зардалд нийт 345,0 сая төгрөгийг батлахад "Ажилттай, орлоготой өрх" дэд хөтөлбөрт зардал батлагдаагүй байна.

Харин дээрх дэд хөтөлбөрүүдээс гадна нэмж "Бид нэг голынхон", "Залуучууд" дэд хөтөлбөрүүдийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээр батлуулан түүнд нийт 38.0 сая төгрөг батлагдсан боловч энэ хөтөлбөрүүд нь аймгийн Засаг даргын 2016-2020 оны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаанаас хэтэрсэн буюу урт хугацаанд хэрэгжих дэд хөтөлбөр тул хэрэгжилтийг аудитад тооцож оруулсангүй.

Улмаар аймгийн ИТХ-ын 2019 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн тогтоолын 6-р хавсралтаар 2020 онд дэд хөтөлбөрүүдийн зардалд нийт 192,0 сая төгрөгийг баталсан байна.

Гэвч тус батлагдсан зардалд "Хэнтий брэнд", "Эрүүл мэнд, Хөгжил, Хөдөлгөөн", "Төрөлх нутагтаа бид", "Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх" болон 2019 оноос хэрэгжсэн "Бид нэг голынхон", "Залуучууд" дэд хөтөлбөрүүдэд зардал батлагдаагүй байна.

Харин "Мянган нуурын хотгор", "Манай гудамж, гэрэлтэй гудамж", "Сумын шинэ төв" дэд хөтөлбөрүүдийн хүрээнд хэрэгжих ажлын зардлыг улс, орон нутгийн хөрөнгө оруулалтын жагсаалтад оруулж батлагджээ.

БҮЛЭГ 2. Дэд хөтөлбөрүүд нь тавьсан зорилтдоо хүрсэн эсэхийг тодорхойлох боломжгүй байна.

Б.1 Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны дунд хугацааны болон жилийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулахдаа санхүүгийн нөөц, хариуцах нэгж, хүрэх чанарын түвшинг бүрэн тодорхойлж чадаагүй байна.

Дунд хугацаанд буюу 2017-2020 онд хэрэгжих дэд хөтөлбөрүүдээс "Эрүүл мэнд-Хөгжил, Хөдөлгөөн", "Архидалтгүй Хэнтий" дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулагдаж батлагдсан байна.

Харин "Ажилтай, орлоготой өрх", "Хэнтийн брэнд", "Бүх нийтийн эрх зүйн боловсрол", "Хоршоог хөгжүүлэх", "Төрөлх нутагтаа бид", "Соёлын бүтээлч

үйлдвэрлэлийг хөгжүүлэх”, “Чингис брэнд” дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх дунд хугацааны үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулагдаагүй байна.

Дэд хөтөлбөрүүдийн тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулахдаа хөтөлбөрт туссан арга хэмжээнүүдтэй уялдуулах, хүрэх түвшин, үр дүн, санхүүгийн нөөц, түүний эх үүсвэрийг тодорхойлох, хариуцах байгууллага, нэгжийг оновчтой тодорхойлж чадаагүй байгаа нь дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг оновчтой тодорхойлж чадаагүйтэй холбоотой байна.

Тухайлбал “Хоршоог хөгжүүлэх” дэд хөтөлбөрийн хэрэгжүүлэх жил бүрийн төлөвлөгөөг өөр өөр бүтэцтэй боловсруулжээ.

Дэд хөтөлбөрүүдийн хүрээнд 62.2 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 6.3 сая төгрөгийг программ хангамжийг худалдан авч нийт 68.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна.

Үүнээс “Хоршоог хөгжүүлэх” дэд хөтөлбөрийн хүрээнд худалдан авсан 44.5 сая төгрөгийн дамарт бороожуулагч бүхий тракторыг Хэрлэн суманд хүлээлгэн өгсөн, 5.8 сая төгрөгийн 3 нэхий элдэх машин, “Ажилтай орлоготой өрх” дэд хөтөлбөрийн хүрээнд 2.0 сая төгрөгийн 1 нэхий элдэх машиныг худалдан авч аймгийн ЗДТГ-ын хөрөнгөнд бүртгэн Хэрлэн сумын 3-р багийн төвд байрлуулсан боловч ашиглагч нь тодорхойгүйгээс өнгөрсөн хугацаанд ашиглаагүй байсныг 2021 онд түрээслэхээр төлөвлөсөн байна.

Эдгээр худалдан авах тоног төхөөрөмжийн ашиглалт, ашиглалтын явцад гарах урсгал зардлыг тооцолгүй хөрөнгө бэлтгэснээс өнөөдрийг хүртэл хэрхэн ашиглах нь тодорхойгүй байна. Төрийн байгууллагын чиг үүрэгт үл хамаарах бизнесийн зориулалттай хөрөнгө бэлтгэснээс үргүй зардал гарч байгаа тул цаашид бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг нь дэмжсэн хөрөнгө оруулалтыг банк болон зээлийн сангаар дамжуулан хэрэгжүүлж байх нь зүйтэй.

ЭЕШ-д бэлтгэгчдийн тест бөглөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор “Төрөлх нутагтаа бид” дэд хөтөлбөрийн хүрээнд 9.9 сая төгрөгийн скантрон засагч машин, түүний 4.8 сая төгрөгийн программ хангамжийг авч аймгийн БСУГ-т, “Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх” дэд хөтөлбөрийн хүрээнд худалдан авсан 1.5 сая төгрөгийн номын сангийн цахим бүртгэлийн “**Lib4U**” программыг аймгийн Нийтийн номын санд хүлээлгэн өгсөн, ашиглалт хэвийн байна.

“Мянган нуурын хотгор”, “Манай гудамж-гэрэлтэй гудамж”, “Сумын шинэ төв” дэд хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлуудын үр дүнд жил бүр гүйцэтгэлийн аудит хийгдэж байсан тул энд давхардуулж оруулсангүй.

Гэвч дээрх хөтөлбөрүүдийн жил бүрийн зорилт, төлөвлөгөө батлагдаагүй, үр дүнг тооцож хөтөлбөрийн биелэлтийг гаргаагүй нь дэд хөтөлбөр батлан хэрэгжүүлэх ач холбогдолтой байсан эсэх нь тодорхойгүй байна.

Б.2 Дэд хөтөлбөрүүдэд шаардлагатай санхүүжилтийг бүрэн тооцоогүй, батлагдсан төсвийн үр ашгийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллаагүй байна.

Дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөг боловсруулахдаа хэрэгжүүлэх гэж байгаа тухайн үйл ажиллагаа нь төрийн ямар байгууллагын чиг үүрэгт хамаарах, тухайн чиг үүргийг хуулийн дагуу иргэн, ААН, ТББ-аар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болох эсэх талаар оновчтой шийдэж чадаагүй байна.

Мөн Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай” хуулийн 15.2¹-т аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийг дэд хөтөлбөрт тусгасан ажил, үйлчилгээ, төсөл арга хэмжээгээр хэрэгжүүлэхээр заасан боловч 2019-2020 онд аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг дэд хөтөлбөрөөс тусад нь баталж дээрхи хуулийн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээнүүдээс аймгийн ЗДТГ-ын хариуцах 66 үйл ажиллагаанаас бусад байгууллага, нэгжээр гүйцэтгүүлж болох цөөнгүй чиг үүрэг байна. Тухайлбал:

- "Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаа",
- "Хонины нэхий боловсруулж, эргэлтэд оруулах",
- "ЖДҮ эрхлэгчдийн бүтээгдэхүүн боловсруулах тасаг бий болгож, "Хэнтийд үйлдвэрлэв" брэнд бүтээгдэхүүний багц гаргах",
- "Малын гаралтай дайвар бүтээгдэхүүний үйлдвэр байгуулах",
- "Арьс ширний анхан шатны боловсруулах үйлдвэр байгуулах" зэрэг ажил болон төрөл бүрийн сургалтуудыг зохион байгуулах ажлуудыг тухайн чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллага, нэгжүүдэд шилжүүлэн гүйцэтгүүлж болохоор байна.

Аймгийн ЗДТГ-ын үндсэн чиг үүрэгт үл хамаарах ажил, үйлчилгээг хариуцахаар төлөвлөгөөндөө тусгасан нь бодлогын мэргэжилтнүүдийн ачааллыг нэмэгдүүлэх, зарим тохиолдолд чанаргүй гүйцэтгэх эрсдэлд оруулсан байж болзошгүй байна.

Дэд хөтөлбөрүүдийн биелэлтийг хянахад дээрх хүчин зүйлүүдийн нөлөөлөл болон бусад шалтгаанаас хамаарч гүйцэтгэл нь хангалтгүй дараах ажлууд байна. Үүнд:


"Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаа"-ы ажилд 8,3 сая төгрөг зарцуулсан ч үр дүнг бүрэн тооцож чадаагүй, баримт материал архивын түвшинд үдэгдэн орхигдсон,
"Хонины нэхий боловсруулж, эргэлтэд оруулах" ажлын 4 тоног төхөөрөмжийг 2018 онд бэлтгэсэн ч өнөөдрийг хүртэл ашиглаагүй,

¹ 15.2 “Засаг дарга аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт үндэслэн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг, түүнийг хэрэгжүүлэх дэд хөтөлбөрийн жагсаалтын хамт боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулна”

"Сум, орон нутгийн онцлог, нөөц бололцоонд тулгуурласан шинэ төрлийн өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх төслүүдийг дэмжих" ажлын хүрээнд тодорхой бүтээгдэхүүн үйлдвэрлэж бий болоогүй,
 "Арьс ширний анхан шатны боловсруулах үйлдвэр байгуулах" ажил хийгдээгүй,
 "Чингис хот дахь бизнесийн инкубатор төв"-ийн үйл ажиллагааг идэвхжүүлэн дэмжих ажил 2017 онд,
 "Бүх нийтийн эрх зүйн боловсрол" дэд хөтөлбөрийн хүрээнд сургагч багш нарыг бэлтгэх сургалт 2017 онд тасалдсан байна.

Мөн "Хэнтий брэнд", "Хоршоог хөгжүүлэх", "Чингэс брэнд" дэд хөтөлбөрүүдийн хүрээнд хийгдсэн зарим ажил, үйлчилгээний агуулга, чиглэл давхцаж байгаа нь ЖДҮ, жижиг бизнес эрхлэгчдийг дэмжих тодорхой бодлого чиглэлгүй, суурь судалгаа муу хийгдсэнтэй холбоотой. Иймд дээрх дэд хөтөлбөрүүдийг нэгтгэн хэрэгжүүлсэн бол тодорхой зардал хэмнэх, илүү үр дүнд хүрэх боломжтой байжээ.

Өнгөрсөн хугацаанд дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд нийтдээ 999.4 сая төгрөгийн санхүүжилтийг баталж, үүнээс 10.1 сая төгрөг хэмнэгдэж, эцсийн гүйцэтгэлээр 989.3 сая төгрөгийг зарцуулсан байна.



Дүрслэл 3

Гэсэн хэдий ч үйл ажиллагааны дунд хугацааны бодлогын баримт бичиг дэд хөтөлбөрүүдэд хяналт хийгдээгүйгээс зарим дэд хөтөлбөрт батлагдсан төсвөөс хэтрүүлэн зарцуулсан зөрчил илэрсэн нь дэд хөтөлбөрт хяналтын төсөвгүй арга хэмжээг баталдаг, дэд хөтөлбөрийн арга хэмжээний зардлыг өөр зардлаас санхүүжүүлдэг зөрчил байна. Жишээ нь:

"Хэнтийн брэнд" дэд хөтөлбөрт 7,7 сая төгрөг, "Эрүүл мэнд-Хөдөлгөөн-Хөгжил" дэд хөтөлбөрт 56,4 сая төгрөг, "Төрөлх нутагтаа бид" дэд

хөтөлбөрт 0,6 сая төгрөгийг дэд хөтөлбөрийн зардлаас бус аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлсэн байна.

Дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд зарцуулсан санхүүжилтийн нийт зардлын 41.6%-ийг урсгал зардлын чанартай зарлагууд эзэлж байна. Тухайлбал:


- Хангамж, бараа материалын зардалд 150.6 сая төгрөг,
- Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал, дэмжлэгт 95.0 сая төгрөг,
- Цалин болон түүнтэй адилтгах зардалд 91.5 сая төгрөг,
- Нормативт зардалд 26.7 сая төгрөг,
- Эд хогшил, урсгал засварт 15.0 сая төгрөг,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжид 65.6 сая төгрөг,
- Бараа үйлчилгээний зардалд 48.4 сая төгрөг зарцуулжээ.

Хэрэв хөтөлбөрийн зорилтуудыг хэрэгжүүлэх ажил, үйлчилгээг оновчтой зөв тодорхойлж, зарим ажил үйлчилгээг иргэн, ААН, ТББ-аар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлсэн бол урсгал зардлыг багасгаж, хөтөлбөрийн үндсэн зорилтыг хэрэгжүүлэхэд зарцуулах санхүүжилтийг нэмэгдүүлж, илүү үр дүн гаргах ажлууд хэрэгжих боломжтой байжээ.

Б.3 Дэд хөтөлбөрүүдийн жил бүрийн хэрэгжилтийг дэвшүүлсэн зорилтын хүрээнд нэгтгэн дүгнээгүй, үр нөлөөг тооцоогүй байна.

Тус дэд хөтөлбөрийн хүрээнд арга хэмжээ бүрээр гаргасан танилцуулга, тайланд дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 2017-2020 онд зарцуулсан санхүүжилт, хүрсэн үр дүнг дурдаж гаргаагүй байна.

"Эрүүл мэнд-Хөдөлгөөн-Хөгжил" дэд хөтөлбөрөөс бусад дэд хөтөлбөрүүдийг боловсруулахдаа хөтөлбөрийн үр дүнг тооцох шалгуур үзүүлэлтүүдийг тодорхой болгоогүйгээс хүлээгдэж байсан үр дүндээ хүрсэн эсэхийг тооцох, түүнийг үнэлэх боломжгүй болгосон байна."Эрүүл мэнд-Хөдөлгөөн-Хөгжил" дэд хөтөлбөрийг батлахдаа үр дүнг тооцох 13 шалгуур үзүүлэлтийг гаргасан боловч 3 үзүүлэлт нь хүрэх түвшинг хангасан, бусад үзүүлэлт нь хүрэх шалгууртаа хүрээгүй байгаа нь чамлалттай үзүүлэлт юм.



Дүрслэл 4

Дэд хөтөлбөрүүдийн жил бүрийн хэрэгжилтийг гаргадаг боловч цаашид авах арга хэмжээ, шаардлагатай санхүүгийн болон хүний нөөцийг тогтоох, ялангуяа олонтоо зохион байгуулсан сургалтууд, туршлага судлах ажлын үр нөлөөг судалж, ахиц дэвшилтийг тооцох талаар бодитой ажил зохион байгуулаагүй байна.

Мөн дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг тооцож, үр дүнг аймгийн ИТХ-д тайлагнасан баримт байхгүй байна.

Дэд хөтөлбөрүүдийн зорилтын хэрэгжилтийн талаар иргэдээс цахим хэлбэрээр санал асуулга явуулахад санал асуулгад төрийн болон орон нутгийн төсөвт байгууллагын 147 ажилтан, албан хаагчид оролцож санал асуулга бөглөсөн байна.

Гэвч санал асуулгад Биндэр, Галшар, Дадал, Дэлгэрхаан, Жаргалтхаан, Мөрөн сумын ЗДТГ, Хэрлэнбаян Улаан тосгоноос нэг ч хүн оролцоогүй.

Санал асуулга өгсөн иргэдийн саналыг нэгтгэн танилцуулбал:

1. Дэд хөтөлбөрүүдийн талаар нийт оролцогчдын 21% нь ойлголт сайн, 38% нь тодорхой хэмжээний ойлголттой байсан бол 27% нь ойлголт муутай, 14% нь хариулт өгөөгүй байсан нь хөтөлбөрүүдийг олон нийтэд танилцуулах, ойлгуулах ажил төдийлөн сайн хийгдээгүй гэж үзэхээр байна. (Хүснэгт №01)
2. Санал асуулгад оролцогчдын 51.2% нь дэд хөтөлбөрүүдийн зорилтууд **"хангалттай биш"** хэрэгжсэн гэж үзжээ. "Манай гудамж-гэрэлтэй гудамж" дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг "сайн" буюу тодорхой үр дүнд хүрсэн гэж оролцогчдын 68.9% үнэлсэн бол "Хоршоог хөгжүүлэх", "Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг

хөгжүүлэх” дэд хөтөлбөрийг “хангалтгүй” буюу хэрэгжилт муу гэж оролцогчдын 37.8-38.8% нь үзсэн байна. (Хүснэгт №02)

3. Дэд хөтөлбөрүүдийн зорилтуудыг тус бүрээр нь авч үзвэл:

“Сайн” хэрэгжсэн” гэж оролцогчдын 74.1% нь “Манай гудамж-гэрэлтэй гудамж” дэд хөтөлбөрийн “Зорилт 1: Чингис хотын хөгжлийн төлөвлөгөө, барилгажилтын төсөлтэй уялдуулан автозамын сүлжээг өргөтгөх”, “Зорилт 2: Чингис хотын гудамж талбай, гэр хорооллын доторх гэрэлтүүлгийг үе шаттай нэмэгдүүлэх” зорилтуудыг,



Дүрслэл 5

“Муу хэрэгжсэн” гэж оролцогчдын 34.0% нь “Хоршоог хөгжүүлэх” дэд хөтөлбөрийн “Зорилт 2: Хоршоог үйлдвэрүүдтэй холбож бүтээгдэхүүнийг кластер хэлбэрээр үйлдвэрлэх, түүхий эдийн бэлтгэн нийлүүлэх үйл ажиллагааг хөгжүүлж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх”, “Чингис брэнд” дэд хөтөлбөрийн “Зорилт 5: Хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх Хятад болон ОХУ-ын жуулчдыг өөрийн аймаг руу татах” зорилтуудыг үнэлсэн байна. (Хүснэгт №03)

БҮЛЭГ 3. Дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтэнд хяналт шалгалт хийгдээгүйгээс үр дүнг тооцох боломжгүй байна.

В.1 Дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд тавигдах дотоод хяналтын нэгжийн ажил хийгдээгүй байна.

Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн хүрээнд батлагдсан 12 дэд хөтөлбөрийн хэрэгжилт, гүйцэтгэлд хийгдсэн дотоод хяналт, түүний мөрөөр хийгдсэн арга хэмжээний талаар аудитын хугацаанд Төрийн аудитын газарт холбогдох материалыг ирүүлсэнгүй.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын дотоод хяналтын нэгж дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд 2017-2020 онд хяналт, шалгалт хийгээгүй байна.

Энэ нь тус хөтөлбөрүүдийг үр дүнтэй хэрэгжүүлэх, зорилго, зорилтыг тодорхой болгох, үр дүнг үнэлэх, хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэх боломжийг алдагдуулсан байна.

В.2 Аймгийн ИТХ-ын хороод нь дэд хөтөлбөрт хяналт тавих ажлаа зохион байгуулаагүй байна.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс баталсан тогтоолын хэрэгжилтэд хяналт тавих үүргийг аймгийн ИТХ-ын дэргэдэх хороодод даалгасан боловч дээрх хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд хяналт хийгдсэн баримт аудитад хамрагдсангүй. Үүнд:

- Нийгмийн бодлогын хорооноос "Эрүүл мэнд-хөдөлгөөн-хөгжил", "Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх", "Ажилтай орлоготой Хэнтийчүүд", "Хэнтий бренд" зэрэг 4 дэд хөтөлбөрт,
- Хөдөө аж ахуй, аялал жуулчлал, байгаль орчны хорооноос "Хоршоог хөгжүүлэх", "Төрөлх нутагтаа бид", "Чингис хаан брэнд" зэрэг 3 дэд хөтөлбөр,
- Хөрөнгө оруулалт, төлөвлөгөө, төсөв, өмчийн хорооноос "Мянган нуурын хотгор", "Манай гудамж-Гэрэлтэй гудамж", "Сумын шинэ төв" зэрэг 3 дэд хөтөлбөрт,
- Хууль эрх зүй, авлига, ёс зүйн хорооноос "Бүх нийтийн эрх зүйн боловсрол", "Архидалтгүй Хэнтий" зэрэг 2 дэд хөтөлбөрт хяналт хийх ажлаа 2017-2020 онуудад огт хийгээгүй байна.

Энэ аймгийн ИТХ баталсан тогтоолуудын хэрэгжилтийг эргэн тооцдоггүй, тавигдсан хяналтын үр дүнг хэлэлцдэггүй, хяналт тавих хороод хяналт тавих ажлаа хангалтгүй гүйцэтгэж байгаатай холбоотой.


Холбогдох байгууллагын санал:


**ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗАР**
23119 Чингис хот, Хэнтий аймаг,
Утас/Факс: 70-56-24-12
E-mail: infoazdg@khentii.gov.mn

2021.03.01 № 3/455
талай 2021.08.23-ны № 106 -т

**АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

Эрүүл мэнд хөдөлгөөн хөгжил дэд хөтөлбөр,
Төрөлх нутагтаа бид хөтөлбөр, Хэнтийн брэнд дэд
хөтөлбөрүүдийн зардал 2020 оны төсөвт батлагдаагүй.
Дэд хөтөлбөрүүдийн зорилго нь аймгийн Засаг даргын
мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн.
Иймд холбогдох зардлыг аймгийн Засаг даргын
мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төсөвт
тусган баталж хэрэгжүүлсэн болно.

САНХҮҮ ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА  С.НЯМДАВАА


СХД-0005 3076803

231070619

Саналд өгсөн тайлбар:

Аудитын тайлангийн төсөлд аймгийн Засаг даргын Тамгын газраас санал ирүүлээгүй тул тайланд өөрчлөлт оруулаагүй болно.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

- Зарим дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулагдаагүй, жил бүрийн зорилт батлагдаагүй байна.
- Дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг үнэлэх үр дүн, шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулж батлуулаагүй байна.
- Зарим дэд хөтөлбөрт зардал батлагддаггүй, санхүүгийн тооцоолол, төсвийн эх үүсвэр тодорхойгүйгээс тухайн жилд хэрэгждэггүй байна.
- Төрийн байгууллагын чиг үүрэгт хамаарахгүй тоног төхөөрөмж, техник хэрэгслийг бэлтгэж, төсвийн хөрөнгө үр дүнгүй зарцуулагдаж байна.
- Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хариуцах байгууллага байхгүй, батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргаагүйгээс зарцуулсан хөрөнгө оруулалт үр дүнгүй болсон байна.
- Аймгийн Засаг даргын Тамгын газар нь дэд хөтөлбөр хэрэгжих 2017-2020 оны хугацаанд “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай” хуулийн 15.7¹-д заасны дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгээгүй байна,
- Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал нь “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай” хуулийн 15.8²-д заасан хөндлөнгийн үнэлгээг дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтэнд зохион байгуулаагүй байна.

¹ **15.7** “Нутгийн захиргааны байгууллага Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж, 02 дугаар сарын 20-ны дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ”

² **15.8** “Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хоёр жил тутам, дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд шаардлагатай тохиолдолд хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурал зохион байгуулна”

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Г.Хэрлэнчулуун-д:

- Аймгийн ИТХ-ын хороод нь хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлж, дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийх үүргээ хэрэгжүүлж байх,

Аймгийн Засаг дарга Ц.Идэрбат-д:

- Дунд хугацааны бодлогын баримт бичгийн зорилтын хэрэгжилт, үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлтүүдийг дэд хөтөлбөртэй хамт баталж байх,
- Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ хэрэгжих хугацаа, санхүүгийн нөөц, хүрэх чанарын түвшин, хариуцах нэгж, албан тушаалтныг тодорхой тусгасан үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж байх,
- Бизнесийн чиглэлтэй тоног төхөөрөмж, техник хэрэгслийг төсвийн хөрөнгөөр бэлтгэхгүй байх, төрийн байгууллагын чиг үүрэгт хамаарахгүй ажилд хөрөнгө зарцуулдаг байдлыг цаашид таслан зогсоох,
- Төрийн байгууллагын чиг үүрэгт хамаарахгүй үйл ажиллагааг иргэн, ААН, ТББ-аар гэрээний үндсэн дээр батлагдсан төсөвт багтаан гүйцэтгүүлж, үр дүнг тооцож байх,
- Аливаа хөтөлбөр, төлөвлөгөөнд хийгдэх дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээг тогтмол хийж, үр дүнг нь үйл ажиллагаандаа тусган дүгнэж байх,
- Хэрэгжилт хангалтгүй, үр дүн тодорхойгүй, төсвийн хөрөнгийн зарцуулалт үр ашиггүй дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхгүй байх,

ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



2021 оны 02 дугаар сарын 05.

Дугаар А/02

Чингис хот

Гүйцэтгэлийн аудитын тайлан баталгаажуулах тухай

Монгол Улсын Ерөнхий аудиторов 2021 оны А/15 дугаар тушаалаар батлагдсан “Нийслэл, аймаг дахь Төрийн аудитын газруудын 2021 онд гүйцэтгэх аудитын сэдэв”-ийг үндэслэн, Монгол улсын Ерөнхий аудиторов 2018 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн А/207 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 2.4 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн аудитын байгууллагын санаачилгаар хийгдэж буй “Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Гүйцэтгэлийн аудитын тайлангаар өгсөн албан шаардлагыг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг audit.mn сайтад бүрэн эхээр нь байршуулан, Үндэсний аудитын газарт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газарт тус тус хүргүүлсүгэй.
4. Гүйцэтгэлийн аудитын тайланд тусгагдсан зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг гүйцэтгэлийн аудитын багийн ахлах аудитор /Д.Эрдэнэбилэг/-т даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР


Ч.ЭРДЭНЭБААТАР

013010010

Дэд хөтөлбөрүүдийн зорилго, зорилт, арга хэмжээ болон шалгуур үзүүлэлтүүд

д/д	Хөтөлбөр	Хөтөлбөр хэрэгжих хугацаа	Аймгийн ИТХ-ын тогтоол			Зорилго, зорилт, үр дүнгийн үзүүлэлтийг тодорхойлсон уу?				Арга хэмжээнүүдийн хэрэгжих боломж тодорхой байна уу?			Шаардлагатай зураг төсөл хийгдсэн үү?		Арга хэмжээнүүдийн үр дүн, шалгуур үзүүлэлт оновчтой байна уу?		
			огноо	дугаар	хяналт	ЗДМХ	Зорилго	Зорилт	Үр дүнгийн үзүүлэлт	Тоо	Цаг хугацаа	Чанарын шалгуур	Тоо	Баталсан	Үр дүн	Шалгуур үзүүлэлт	Харилцан уялдаа
Мөрийн хөтөлбөр хэрэгжүүлэх дэд хөтөлбөр																	
1	Ажилтай, орлоготой өрх	2017-2020	2017-01-26	№07	Нийгмийн бодлогын хороо	1.6.2	1	2		11					4	0	
2	Хэнтийн брэнд	2017-2020	2017-01-30	№12	ХАА, аялал жуулчлал, байгаль орчны хороо	2.2.2	1	4		11					0	7	
3	Эрүүл мэнд-Хөдөлгөөн-Хөгжил	2017-2020	2017-01-26	№08	Нийгмийн бодлогын хороо	1.4.2	1	3		16					0	18	
4	Архидалтгүй Хэнтий	2017-2020	2017-01-26	№09	Хууль эрх зүй, авилга ёс зүйн хороо	4.3.7	1	6		31					5	0	
5	Бүх нийтийн эрх зүйн боловсрол	2017-2020	2017-01-26	№10	Хууль эрх зүй, авилга ёс зүйн хороо	4.3.8	1	2		10					5	0	
6	Мянган нуурын хотгор	2017-2020	2017-01-30	№11	Хөрөнгө оруулалт, төлөвлөлт, төсөв, өмчийн хороо	2.1.5	1	2		4					5	3	
7	Манай гудамж-гэрэлтэй гудамж	2017-2019	2017-01-30	№11	Хөрөнгө оруулалт, төлөвлөлт, төсөв, өмчийн хороо	2.1.4	1	3		3					3	4	
8	Сумын шинэ төв	2017-2020	2017-01-30	№11	Хөрөнгө оруулалт, төлөвлөлт, төсөв, өмчийн хороо	2.1.7	1	3		5					5	4	
9	Хоршоог хөгжүүлэх	2017-2020	2017-01-30	№13	ХАА, аялал жуулчлал, байгаль орчны хороо	2.2.11	1	2		20					7	3	
10	Төрөлх нутагтаа бид	2017-2020	2017-01-26	№06	Нийгмийн бодлогын хороо	1.2.19	1	2		13					6	15	
11	Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх	2017-2020	2017-01-30	№15	Нийгмийн бодлогын хороо	1.3.2	1	3		10					0	6	
12	Чингис брэнд	2017-2020	2017-02-09	№17	ХАА, аялал жуулчлал, байгаль орчны хороо	3.2.1	1	6		13					2	0	
НИЙТ ДҮН							12	38	0	147					42	60	
Бусад дэд хөтөлбөр																	
1	Залуучуудын хөгжлийг дэмж	2018-2022	2018-07-30	№42	Нийгмийн бодлогын хороо		1	5		51					4	16	
2	Бид нэг голынхон	2019-2030	2018-04-04	№22			1	3		32					7		

Судалгаа гаргасан: Ахлах аудитор



Д.Эрдэнэбилэг

Судалгаа №

ДЭД ХӨТӨЛБӨРҮҮДИЙН БАТЛАГДСАН ТӨСӨВ, ГҮЙЦЭТГЭЛ

2021-02-08

	АИТХ 2017/12/01 №01 2017 он		АИТХ 2018/09/26 №05 2018 он		АИТХ 2019/05/17 №02 2019 он		АИТХ 2019/12/04 №08 2020 он		БҮГД ДҮН		
	Батлагдсан	Зарцуулсан	Батлагдсан	Зарцуулсан	Батлагдсан	Зарцуулсан	Батлагдсан	Зарцуулсан	Батлагдсан	Зарцуулсан	Зөрүү
Ажилтай, орлоготой өрх	0.00	0.00	30.00	15.39	14.40	14.40	50.00	0.00	94.40	29.79	64.61
Хэнтийн брэнд	0.00	0.00	20.00	20.00	19.00	22.75		4.00	39.00	46.74	-7.74
Эрүүл мэнд-Хөдөлгөөн-Хөгжил	154.23	109.76	100.00	100.00	122.60	115.48		108.00	376.83	433.24	-56.42
Архидалтгүй Хэнтий	4.22	3.00	25.00	24.15	28.00	26.99	10.00	10.00	67.22	64.14	3.08
Бүх нийтийн эрх зүйн боловсрол	0.35	0.25	20.00	20.00	30.00	31.20	22.00	18.80	72.35	70.25	2.10
Хоршоог хөгжүүлэх	0.00	0.00	20.00	19.91	14.00	13.99	50.00	44.46	84.00	78.37	5.63
Төрөлх нутагтаа бид	0.00	0.00	20.00	20.60	23.00	23.00		0.00	43.00	43.60	-0.60
Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх	18.57	13.22	30.00	29.88	38.00	37.91		0.00	86.57	81.01	5.56
Чингис брэнд	0.00	0.00	20.00	19.30	59.00	59.78	60.00	36.59	139.00	115.68	23.32
Бид нэг голынхон					9.00	9.00			9.00	9.00	0.00
Залуучуудын хөгжлийг дэмжих					19.00	17.49			19.00	17.49	1.51
"Их түмэн санаачлага" олон улсын хурал					20.00	20.00			20.00		
НИЙТ ДҮН	177.37	126.23	285.00	269.23	396.00	391.99	192.00	221.85	1,050.37	989.31	41.06
Мянган нуурын хотгор	0.00	0.00		0.00		0.00		0.00	0.00	0.00	0.00
Манай гудамж-гэрэлтэй гудамж	0.00	0.00		0.00		0.00		0.00	0.00	0.00	0.00
Сумын шинэ төв	0.00	0.00		0.00		0.00		0.00	0.00	0.00	0.00
НИЙТ ДҮН	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00

Батлагдсан төсвийг хэтрүүлсэн:	-64,757,841.89
Батлагдсан төсвийг зарцуулаагүй:	105,816,949.89

Тайлбар: 2017 онд дэд хөтөлбөрийн зардалд 177.3663 сая.төг бөөнд нь баталсан

Судалгаа гаргасан: Аудитор



Ц.Энхтүвшин

АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛСЭН ДЭД ХӨТӨЛБӨРҮҮДИЙН ЗАРДЛЫН СУДАЛГАА

ДЭД ХӨТӨЛБӨРҮҮД	НИЙТ ЗАРЦУУЛСАН	2101 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2103 Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	2104 Хангамж, бараа материалын зардал	2105 Нормативт зардал	2106 Эд хогшил, урсгал засвар	2107 Томилолт, зочны зардал	2132 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	ДҮН	Хувь	2108 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2109 Бараа үйлчилгээний бусад зардал	2200 Барилга байгууламж	2220 Тоног техөөрөмж	2230 Бусад хөрөнгө
БҮГД ДҮН	1,569.57	91.51	0.00	150.56	26.91	15.00	32.47	95.01	411.45		65.55	49.44	540.66	62.16	6.30
Ажилтай, орлоготой өрх	29.79	0.00	0.00	2.33	0.16	0.00	0.00	10.90	13.39	44.9%	0.00	0.00	0.00	2.00	0.00
Хэнтийн брэнд	46.74	0.18	0.00	18.54	3.13	4.00	2.13	9.28	37.27	79.7%	2.00	6.45	0.00	0.00	0.00
Эрүүл мэнд-Хөдөлгөөн-Хөгжил	433.24	77.90	0.00	3.63	3.33	1.49	1.27	9.30	96.91	22.4%	22.50	3.85	0.00	0.00	0.00
Архидалтгүй Хэнтий	64.14	6.83	0.00	4.67	8.10	3.01	1.31	3.65	27.57	43.0%	10.29	11.37	0.00	0.00	0.00
Бүх нийтийн эрх зүйн боловсрол	70.25	1.64	0.00	15.43	6.83	1.70	7.83	5.88	39.31	56.0%	10.10	11.58	0.00	0.00	0.00
Хоршоог хөгжүүлэх	78.37	0.57	0.00	8.91	4.19	1.90	4.34	1.20	21.11	26.9%	1.50	5.38	0.00	50.26	0.00
Төрөлх нутагтаа бид	43.60	0.00	0.00	7.70	0.60	0.00	0.00	12.88	21.18	48.6%	0.00	1.56	0.00	9.90	4.80
Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх	81.01	1.89	0.00	24.06	0.00	2.90	4.96	27.19	60.99	75.3%	0.00	0.00	0.00	0.00	1.50
Чингис брэнд	115.68	0.00	0.00	63.64	0.56	0.00	7.33	11.73	83.27	72.0%	19.16	6.95	0.00	0.00	0.00
Бид нэг голынхон	9.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.0%	0.00	0.00	0.00	0.00	0.00
Залуучуудын хөгжлийг дэмжих	17.49	2.50	0.00	1.65	0.00	0.00	3.30	3.01	10.46	59.8%	0.00	2.30	0.00	0.00	0.00
НИЙТ ДҮН	989.31	91.51	0.00	150.56	26.91	15.00	32.47	95.01	411.45	41.6%	65.55	49.44	0.00	62.16	6.30
Мянган нуурын хотгор	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	#DIV/0!	0.00	0.00	0.00	0.00	0.00
Манай гудамж-гэрэлтэй гудамж	39.60	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.0%	0.00	0.00	0.00	0.00	0.00
Сумын шинэ төв	540.66	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.0%	0.00	0.00	540.66	0.00	0.00
НИЙТ ДҮН	580.26	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00		0.00	0.00	540.66	0.00	0.00

Судалгаа гаргасан: Аудитор



Ц.Энхтүвшин

ДЭД ХӨТӨЛБӨРҮҮД НЬ ТАВСАН ЗОРИЛТДОО ХҮРЧ, ҮР ДҮН ГАРСАН ЭСЭХ

2 дахь түвшний асуулт	Дэд хөтөлбөрүүд нь тавьсан зорилтдоо хүрч үр дүн гарсан уу?																			
3 дахь түвшний асуулт	Дэд хөтөлбөрийн санхүүжилтийг арвилан хэмнэлттэй зарцуулсан уу?										Дэд хөтөлбөрүүдийг үр ашигтай хэрэгжүүлсэн үү?									
	Санхүүжилт			Төрийн чиг үүрэгт хамаарна гэж төлөвлөсөн арга хэмжээ		Иргэн, ААН, ТББ-аар гүйцэтгүүлнэ гэж төлөвлөсөн арга хэмжээ		Үүнээс: Иргэн, ААН, ТББ-аар гүйцэтгүүлсэн арга хэмжээ		Үр ашгийг хүртсэн (давхардсан тоогоор)				Арга хэмжээний хэрэгжилт			Бий болсон өмч			
	Батлагдсан	Зарцуулсан	Хэмнэлт	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Өрх	ААН	ТББ	Төсөвт байгууллага	Бүрэн хэрэгжсэн	Дутуу хэрэгжсэн	Огт хэрэгжээгүй	Барилга байгууламж	Тоног төхөөрөмж	Бусад хөрөнгө
Ажилтай, орлоготой өрх	80.0	29.8	50.2	17		6		1		6559	0	104	0	17	10	2	1	-	2.0	-
Хэнтийн брэнд	29.0	46.7	(17.7)	49		0		1		1657	40	203	2	4	39	3	10	-	-	-
Эрүүл мэнд-Хөдөлгөөн-Хөдөлмөр	370.2	433.2	(63.0)	109		0		14		202841	0	0	0	12	68	2	12	-	-	-
Архидалтгүй Хэнтий	67.2	64.1	3.1	57		21		13		5358	0	0	4	0	28	0	21	-	-	-
Бүх нийтийн эрх зүйн боловсрол	72.4	70.3	2.1	68											70	0	0	-	-	-
Хоршоог хөгжүүлэх	84.0	78.4	5.6	31		0		0		459	0	482	0	0	31	0	0	-	50.3	-
Төрөлх нутагтаа бид	43.0	43.6	(0.6)	22		7		2		4129	0	0	1	19	20	0	2	-	9.9	4.8
Соёлын бүтээлч үйлдвэрлэл	86.6	81.0	5.6	6		2		0		700	0	0	0	1	5	1	2	-	-	1.5
Чингис брэнд	139.0	115.7	23.3	26		0		3		7638	2	47	0	4	20	0	0	-	-	-
Бид нэг голынхон	9.0	9.0	-																	
Залуучуудын хөгжлийг дэмжих	19.0	17.5	1.5																	
НИИТ ДҮН	999.4	989.3	10.1	385	-	36	0	34	-	229341		836		57	291	8	48	-	62.2	6.3
Мянган нуурын хотгор	-	-	-																	
Манай гудамж-гэрэлтэй гудамж	-	-	-																	
Сумын шинэ төв	-	-	-																	
НИИТ ДҮН	-	-	-	#	-	#	-	#	-	-		#		-	-	-	-	-	-	-

Тайлбар: 2020 онд хэрэгжүүлэх 24 арга хэмжээ нь хөл хорио тогтоосонтой холбоотой хэрэгжүүлэх боломжгүй болсон байна.

Судалгаа гаргасан: Аудитор

Ц.Энхтүвшин

"Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилт, үр дүн, үр ашиг"
аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**Огноо:****2021-02-25****Аудитын
нэр:***"Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд
чиглэгдсэн хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилт, үр дүн, үр ашиг"***Аудитын код:****ХЭА-2021/02-ГА****Шалгагдсан байгууллагын нэр:****Аймгийн ИТХ-ын ажлын алба, аймгийн Засаг даргын Тамгын газар,****Сая төгрөгөөр**

№	Аудитын зорилт, чиглэл	Тоо	Алдаа зөрчлийн товч утга	Мөнгөн дүн /сая.төг/	Аудитын байгууллагын гаргасан шийдэл			Алдаа зөрчилтэй асуудал гаргасан байгууллага албан тушаалтан		
					Нэр	Огноо	Дугаар	Байгууллагын нэр	Албан тушаал	Овог, нэр
1		2	3	4	5	6	7	8	9	10
1	1.1 Төлөвлөгдсөн дэд хөтөлбөрүүдийн хэрэгцээ шаардлага нь бодитой байсан уу?		Аймгийн Засаг даргын 2016-2020 оны мөрийн хөтөлбөр, түүний хүрээнд хэрэгжүүлэх 12 дэд хөтөлбөрийг ном болгон хэвлэхдээ "Чингис хаан бренд"-ын дэд хөтөлбөрийн зорилтоос 2 зорилтыг орхигдуулсан байна.	-	Зөвлөмж	2021.03.05	279	АЗДТГ-ын ХОХБТХ	дарга	Э.Мөнх-Эрдэнэ
2	1.2 Дэд хөтөлбөрүүдийн хүрэх үр дүнг тодорхойлж, төсвийг үндэслэлтэй баталсан уу?		Гэвч 2018 оны дэд хөтөлбөрүүдийн санхүүжилтээс "Ажилтай, орлоготой өрх", "Хэнтий брэнд", "Хоршоог хөгжүүлэх", "Төрөлх нутагтаа бид", "Чингис брэнд", 2019 онд "Ажилтай орлоготой өрх" дэд хөтөлбөрүүдэд зардал батлаагүй байна.	-	Зөвлөмж	2021.03.05	279	АЗДТГ-ын ХОХБТХ, НБХ	дарга	Э.Мөнх-Эрдэнэ, Г.Лхагвахатан
3	2.1 Дэд хөтөлбөрүүдийг үр ашигтай хэрэгжүүлсэн үү?		"Ажилтай, орлоготой өрх", "Хэнтийн брэнд", "Бүх нийтийн эрх зүйн боловсрол", "Хоршоог хөгжүүлэх", "Төрөлх нутагтаа бид", "Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх", "Чингис брэнд" дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх дунд хугацааны үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулагдаагүй.	-	Зөвлөмж	2021.03.05	279	АЗДТГ-ын ХОХБТХ, НБХ	дарга	Э.Мөнх-Эрдэнэ, Г.Лхагвахатан


4	2.1 Дэд хөтөлбөрүүдийг үр ашигтай хэрэгжүүлсэн үү?		"Мянган нуурын хотгор, "Манай гудамж-гэрэлтэй гудамж", "Сумын шинэ төв" дэд хөтөлбөрүүдийн жил бүрийн зорилт, төлөвлөгөө батлагдаагүй, үр дүнг тооцоогүй	-	Зөвлөмж	2021.03.05	279	АЗДТГ-ын ХОХБТХ	дарга	Э.Мөнх-Эрдэнэ
5	2.2 Дэд хөтөлбөрийн санхүүжилтийг арвилан хэмнэлттэй зарцуулсан уу?		"Өрхийн амжиргааны түвшин тогтоох судалгаа"-ы ажилд 8,3 сая төгрөг зарцуулсан ч үр дүнг бүрэн тооцоогүй, материал архивын түвшинд үдэгдэн орхигдсон, "Хонины нэхий боловсруулж, эргэлтэд оруулах" ажлын 4 тоног төхөөрөмжийг 2018 онд бэлтгэсэн ч өнөөдрийг хүртэл ашиглаагүй, "Сум, орон нутгийн онцлог, нөөц бололцоонд тулгуурласан шинэ төрлийн өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх төслүүдийг дэмжих" ажлын хүрээнд тодорхой бүтээгдэхүүн бий болоогүй байна. Харин "Арьс ширны анхан шатны боловсруулах үйлдвэр байгуулах" ажил, "Чингис хот дахь бизнесийн инкубатор төв"-ийн үйл ажиллагааг идэвхжүүлэх ажил, "Бүх нийтийн эрх зүйн боловсрол" дэд хөтөлбөрийн хүрээнд сургагч багш нарыг бэлтгэх сургалт тасалдсан байна.	8.3	Зөвлөмж	2021.03.05	279	АЗДТГ-ын ХОХБТХ	дарга	Э.Мөнх-Эрдэнэ
6	2.2 Дэд хөтөлбөрийн санхүүжилтийг арвилан хэмнэлттэй зарцуулсан уу?		"Хоршоог хөгжүүлэх" дэд хөтөлбөрийн хүрээнд 44.5 сая төгрөгийн трактор, дамарт бороожуулагч, 5.8 сая төгрөгийн 3 ширхэг нэхий элдэх машин, "Ажилтай орлоготой өрх" дэд хөтөлбөрийн хүрээнд 2.0 сая төгрөгийн нэхий элдэх машин зэрэг төсвийн байгууллагын чиг үүрэгт хамаарахгүй, үйл ажиллагаанд шаардлагагүй хөрөнгө бэлтгэсэн	52.3	Албан шаардлага	2021.03.05	80	Аймгийн ЗДТГ	Засаг дарга	Ц.Идэрбат

7	2.2 Дэд хөтөлбөрийн санхүүжилтийг арвилан хэмнэлттэй зарцуулсан уу?		Нийт дүнгээр "Хэнтийн брэнд" дэд хөтөлбөрт 7,7 сая төгрөг, "Эрүүл мэнд-Хөдөлгөөн-Хөгжил" дэд хөтөлбөрт 56.4 сая төгрөг, "Төрөлх нутагтаа бид" дэд хөтөлбөрт 0,6 сая төгрөгийг тус тус батлагдсан төсвөөс илүү зарцуулсан нь дэд хөтөлбөрүүдийн төсвийг батлахдаа хяналтын төсөвгүйгээр санхүүжилтийг баталсан.	64.7	Албан шаардлага	2021.03.05	79	АЗДТГ-ын СТСХ	дарга	С.Нямдаваа
8	3.1. Дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд тавих дотоод аудит үр дүнтэй хийгдсэн эсэх		Аймгийн Засаг даргын Тамгын газрын дотоод хяналтын нэгж дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд 2017-2020 онд хяналт, шалгалт хийгээгүй байна	-	Зөвлөмж	2021.03.05	279	АЗДТГ-ын ХШҮДАХ	үүргийг түр орлон гүйцэтгэгч	Ц.Ганчимэг
9	3.2. Аймгийн ИТХТ-ын тогтоолын хэрэгжилтэд хяналт тавигдсан эсэх		Аймгийн ИТХ-ын дэргэдэх аймгийн ИТХ-ын төлөөлөгчдөөс бүрдсэн хороод нь 2017-2020 онуудад хариуцсан дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналтын ажил хийгээгүй байна.	-	Зөвлөмж	2021.03.05	279	Аймгийн ИТХ-ын дэргэдэх НБХороо, ХАААЖБОХороо, ХЭЗАЕЗХороо, ХОТТӨХороо	дарга	С.Мөнхцэцэг, Б.Дархантөр, Л.Батсайхан, Ц.Идэрбат
		0	Зөрчлийн дүн	125.3						

Бэлтгэсэн: Аудитор

Анхан шатанд хянасан: Ахлах аудитор

Хоёр дахь шатанд хянасан: Аудитын менежер



Ц.Энхтүвшин

Д.Эрдэнэбилэг

Д.Оюунтуяа

Огноо.....

Огноо 2021-03-05

Огноо 2021-03-05